ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Чойр хот

2023 онд хэлтсийн дарга 1, СБТасгийн дарга-ахлах нягтлан бодогч 1, Үйлчилгээний тасгийн дарга-хяналт шалгалт, дотоод аудитын байцаагч 1, Тэтгэврийн байцаагч 1, Тэтгэмж, сайн дурын байцаагч 1, Шимтгэл орлогын байцаагч 1, Нийгмийн хамгаалалын хяналтын байцаагч 1, Магадлагч эмч 1, Шивээговь сумын байцаагч 1 нийт 9 төрийн захиргааны албан хаагч, Сангийн нягтлан бодогч 1, Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн-сүлжээний инженер 1, Хүний нөөц, архив, бичиг хэрэг-дотоод ажил хариуцсан ажилтан 1 нийт төрийн үйлчилгээний ажилтан 4, үйлчлэгч 1, харуул 3 нийт 4 туслан гүйцэтгэх ажилтан бүгд 17 ажилтан 2 тасгийн зохион байгуулалтайгаар үйл ажиллагаа явуулж нийгмийн даатгалын үйлчилгээг аймгийн иргэд даатгуулагчдад хүргэн тэтгэвэр, тэтгэмжийг сар бүр тогтоон олгох, нийгмийн даатгалын шимтгэлийг хугацаанд нь төвлөрүүлэх, өр авлага барагдуулах, шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах зэрэг ажлуудыг гүйцэтгэж ирлээ.

Нийгмийн даатгалын сангуудын талаар:

2023 онд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 220 байгууллагын 5412 заавал даатгуулагч, сайн дурын 685 даатгуулагч нийт 6097 даатгуулагчийг хамруулан нийгмийн даатгалын санд 11 сарын байдлаар 16236223,0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулахаас 15214337,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төвлөрүүлж төлөвлөгөө 94 хувийн биелэлттэй байна.

12 дугаар сард 3150492,1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төвлөрүүлэн орлогын төлөвлөгөө 100 хувиар биелэнэ.

Шивээ-овоогийн нүүрсний уурхайн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 4 сараар тасарсан нь орлогын төлөвлөгөөнд нөлөөлж байгаа боловч үлдсэн 12 сард дангаараа 3 сарын төлөлт 1,5 тэр бум төгрөг төлөх гэрээний үүрэгтэй тул жилийн эцсийн орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүлнэ.

Нийгмийн даатгалын сангаас 25112739,4 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгож зарцуулахаас эхний 11 сарын байдлаар 4824 дааргуулагчид 20540927,4 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмж олгож төв санд 2553132,3 мянган төгрөг төвлөрүүлэн ажилласан байна.

1. Тэтгэврийн даатгалын сан:

Тэтгэврийн даатгалын санд 13187574,2 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 12612988,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулж Өндөр насны тэтгэвэр 2011 иргэнд 14522858,6 мянган төгрөг, Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 312 иргэнд 1608050,9 мянган төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 129 иргэнд 626580,6 мянган төгрөг, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр 125 иргэнд 1450572,1 мянган төгрөгийн нийт 2577 иргэнд 18208062,2 мянган төгрөгийн тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр хугацаанд нь бүрэн олгосон байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зарцуулагдаагүй орлогын үлдэгдэлээс НДЕГ-ын төвлөрсөн төв харилцахад 1743132,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэн ажиллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 238, 239 дүгээр тогтоолоор баталсан "Иргэдийн тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлс, инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх", "Итгэлцүүр батлах тухай" тогтоолын дагуу иргэдийн тэтгэврийг богино хугацаанд нэмэгдүүлэн олгох ажлыг 6 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд хэлтсийн байцаагч нар түргэн шуурхай зохион байгуулан 07 дугаар сарын 01-ний өдөр тэтгэврийг нэмэгдсэн хэмжээгээр бүрэн олгож ажиллаа. Тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээнд нийт 2583 иргэн хамрагдан сард олгох тэтгэврийн хэмжээ 565,734.7 мянган төгрөгөөр, тухайн онд 3,394,408.2 мянган төгрөгийн нэмэлт хөрөнгө зарцуулсан байна.

Тэтгэврээ өөрчлөн тогтоолгох хүсэлтэй 113 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч 30 иргэний тэтгэврийг 15.0-416.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон байна.

Энэ онд өндөр насны 139, хөдөлмөрийн чадвараа алдсаны 32, тэжээгчээ алдсаны 17 нийт 188 иргэнд шинээр тэтгэвэр тогтоон олголоо.

2. Тэтгэмжийн даатгалын сан:

Тэтгэмжийн даатгалын санд 1382756,3 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 1191336,9 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого оруулж сангаас Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж 1571 даатгуулагчид 253515,9 мянган төгрөг, Жирэмсэн ба амаржсаны тэтгэмж 337 даатгуулагчид 831478,9 мянган төгрөг, Оршуулгын тэтгэмж 63 даатгуулагчид 126000,0 мянган төгрөг, банкны үйлчилгээний хөлс бусад зардалд 8462,0 мянган төгрөг нийт 1971 даатгуулагчид 1219456,9 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.

Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмж, Жирэмсэн амаржсаны ҮОМШӨ-ний ХЧТА тэтгэмжүүдийг цахимаар хүлээн авч, хянан баталгаажуулан түргэн шуурхай үйлчилгээг иргэд

даатгуулагчид хүргэн ажиллаа.

3. ҮОМШӨ-ний даатгалын сан:

ҮОМШӨ-ний даатгалын санд 1368688,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлого оруулахаас 117551,4 мянган төгрөг шимтгэлийн орлого оруулж даатгалын сангаас Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 36 иргэнд 291006,4 мянган төгрөг, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 6 иргэнд 53158,6 мянган төгрөг, ХЧАТэтгэмж 3 даатгуулагчид 777,3 мянган төгрөг, даатгуулагчийн унааны зардал 1 иргэнд 126,1 мянган төгрөг, ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх сургалтын зардалд 5000,0 мянган төгрөгийг олгож НДЕГ-ын төв санд 810000,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн нийт 1236282,7 мянган төгрөг зарцуулан ажиллав.

4. Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 298300,0 мянган төгрөгийн шимтгэл оруулахаас 234511,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулж тус даатгалын сангаас 230 даатгуулагчид 761738,7 мянган төгрөгийн тэтгэмж олгон бусад зардалд 1601,2 мянган төгрөг нийт 763339,9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

5. Эрүүл мэндын даатгалын сан

Эрүүл мэндийн даатгалын санд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 2445,1 сая төгрөгийн шимтгэл хураамж оруулахаас 2579,7 сая төгрөг төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг 105 хувиар давуулан биелүүлж сард орсон орлогыг тухай бүр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт бүрэн шилжүүлэн ажиллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулалтын талаар:

Хэлтсийн даргын 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/34 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах" 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг томилогдон дараах ажлыг зохион байгуулж хийж гүйцэтгэлээ.

Өмнөх оны жилийн эцсээр 68 аж ахуйн нэгжийн 6475598,7 мянган төгрөгийн авлага үүсгэсэн аж ахуй нэгжийн удирдлагуудтай уулзаж, гэрээ байгуулан, албан шаардлага хүргүүлж, банкин дахь зарлагын гүйлгээг хаах зэрэг ажлуудыг зохион байгуулсанаар 56 аж ахуй нэгжийн

2800056,6 мянган төгрөгийн авлагыг барагдууллаа. Аймгийн Прокурорын газартай хамтран 6 аж ахуй нэгжийн 201204,0 мянган төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулахаар шүүхэд нэхэмжилж, 4 аж ахуй нэгжийн 89000,0 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулж үлдэгдэл авлагыг энэ онд багтаан барагдуулах гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Өмнөх онуудад шүүхээр шийдвэрлэгдэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд бүртгэлтэй өр барагдуулах ажиллагаа хийгдэж байгаа /Чойрхайрхан-170,2, Говьгео ХХК-46,9, Тохилог сууц СӨХ-3,3 / нийт 220476,0 мянган төгрөгийн авлагаас 14000,0 мянган төгрөг барагдсан байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн шимтгэлийн авлага 2023 оны 11 сарын байдлаар нийт 8359762,4 мянган төгрөгийн үлдэгдэл авлага бүртгэгдсэний 85 хувь буюу 7076013,2 мянган төгрөгийн авлагыг нүүрсний уурхай Шивээ-Овоо ХК дангаараа эзлэж байна.

авлагыг барагдуулахаар Шивээ-Овоо ХК-ий нийгмийн даатгалын шимтгэлийн байгууллагын удирддах албан тушаалтнуудтай удаа дараа уулзаж албан шаардлага хүргүүлж, гэрээ байгуулан ажиллаж байгаа боловч тодорхой үр дүнд хүрээгүйгээр барахгүй шинээр өр

Шивээ-Овоо ХК-ий Гүйцэтгэх захирал н. Энхтүвшин Засгийн газраас нүүрсний үнийг хатуу авлага үүсч байна. баридаг, олборлож байгаа нүүрсний үнээс бага үнээр нүүрс борлуулагдаг нь татвар, НД-ийн шимтгэлийн өр, авлага үүсэх үндсэн шалтгаан болоод байна. Үнийн зөрүүг нөхөх ямар ч болгомжгүй учир боломж гарахгүй байна гэсэн ганц тайлбар хэлдэг банкны харилцах дансны зарлагын гүйлгээг хааж үзсэн Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс 4-р цахилгаан станцыг нүүрсээр хангадаг ажлыг санаатайгаар саатуулсан гэх асуудал ярьж хүндрэлтэй байдал үүсгэдэг зэрэг олон шалтгаан, хүчин зүйлс нөлөөлдөг.

Цаашид тухайн компанийг аймгийн Прокурорын газартай хамтран өр авлагыг шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын хамрагдалтын талаар:

Нийгмийн даатгалын хуулийг иргэд даатгуулагчид ойлгуулах, сурталчилан таниулах сайн дурын даатгалд хамрагдсанаар нийгмийн даатгалын сангаас хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр багуудын өдөрлөгт, зах худалдааны төв, хүн ихээр цугладаг газруудаар хууль тогтоомжийн танилцуулга, гарын авлага тараах, иргэдийн уулзалт ярилцлагыг 4 удаа ажил зохион байгууллаа.



Сүмбэр, Баянтал, Шивээговь сумын 5 багийн өдөрлөгт оролцож малчин иргэдэд хөдөлмөрийн тухай хуулийн зүйл заалт болон сайн дурын даатгал, малчдын тэтгэврийн талаар 7 удаагийн сургалт зохион байгуулж 308 иргэн хамруулав.

Багийн дарга нараар дамжуулан нийгмийн даатгалын сурталчилгааны тараах 300 материалыг малчин иргэдэд түгээлээ.

Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, иргэдийг мэдээллээр хангах зорилгоор зөөврийн мэдээллийн самбарыг зах, худалдааны төв, арилжааны банкуудад байршуулан сурталчилж байна.

Хэлтсийн мэдээллийн лавлах утсанд хандсан 502 даатгуулагчийн асуултад хариулан зөвлөгөө тайлбар өгч ажилласан байна.

2023 онд дээрхи ажлуудыг зохион байгуулснаар шинээр 18 ажил олгогч, түүнд ажиллагч 62 даатгуулагч, сайн дурын даатгалд 183 иргэн, малчин даатгуулагч 63 нийт 308 даатгуулагчийг хамруулан сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх оноос 30% -иар нэмэгдсэн байна.


Хяналт шалгалтын ажлын талаар:

Хэлтсийн даргын баталсан 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн удирдамжаар 40 ААНБ-ыг шалгаж, 22 байгууллагад 16285.2 мянган төгрөгийн актыг тогтоож актын барагдуулалт 90% хувьтай байна.

Дотоод хяналт шалгалтын батлагдсан төлөвлөгөөний дагуу тэтгэвэр олголт давхардалыг 11 дүгээр сарын 01-ний байдлаар шалгаж 20 тэтгэвэр авагч иргэнд 6693.9 мянган төгрөгийг дутуу олгосон, 20 тэтгэвэр авагч иргэнд 4148.8 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд улсын байцаагчийн акт тогтоон бүрэн барагдуулж санг хохиролгүй болгож ажиллаа.

2023 онд гүйцэтгэх дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөгөөр нийт 40 аж ахуй нэгжид шалгалт явуулж 20 ААНБайгууллагын дутуу тайлагнасан 16285,2 мянган төгрөгийн НДШимтгэлийн орлогод акт тогтоон шалгалтын явцад 100 хувь барагдуулсан байна.

Хэлтсийн даргын тушаалаар байгуулсан ажлын хэсэг 2023 онд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа 2738 иргэний тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримт бичгийн тооллого явуулсанаас өндөр насны тэтгэвэр 2197, тэжээгчээ алдасны тэтгэвэр 148, тахир дутуугийн тэтгэвэр 398 иргэний тэтгэвэр олгосон файл, жагсаалттай тулган



баталгаажуулалт хийхэд зөрчил илрээгүй болно. Шалгалтын тайланг хэлтсийн ажилтнуудын хуралд танилцуулав.

Нийгмийн даатгалын салбарын цахим хяналтын веб програм http://10.9.0.5/monitoring)-аас нийт 1660 зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг нэг бүрчлэн шалгаж жирэмсэн амаржсаны тэтгэмжийн эрх үүсээгүй даатгуулагчид 752.0 мянган төгрөгийн тэтгэмжийг илүү олгосон зөрчилд улсын байцаагчийн акт тогтоон санд буцаан төлүүлэв. Даатгуулагчийн төрөл цалин зөрсөн зөрчлийг тухай бүр залрууллаа.

Дотоод болон гадаад сургалтын талаар

2023 онд Нийгмийн даатгалын хэлтсийн албан хаагчдыг мэргэшүүлэх, шинэ ажилтныг чадавхижуулах дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу хийсэн сургалт 7, НДЕГ-ын газраас зохион байгуулсан сургалт 3, Аймгийн Засаг даргын Тамгын газраас төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, авлигаас ангид байх чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгууллаа. Нийт-12 удаагийн сургалтанд хэлтсийн 15 албан хаагч бүрэн хамрагдсан байна.

Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлөөс аймгийн нийт төрийн албан хаагчдад зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 цахим сургалт хэлтсийн нийт албан хаагчид хамрагдаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан 4 удаагийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх сургалтанд нийт албан хаагчид хамрагдсан.

Шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу 5 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ёс зүйн дэд хороо байгуулан 4 удаагийн төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг хийв.

Төрийн албан хаагчийн богино хугацааны Удирдлагын академын сургалтанд үйлчилгээний тасгийн дарга Ц.Бямбасүрэн хамрагдаж томилолтын зардлыг шийдсэн

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, мөн Нийгмийн даатгалын ач холбогдлыг таниулах сургалт мэдээллийг Хэлтсийн даргын төлөвлөгөөний дагуу 50 удаагийн сургалтыг нийт 1193 иргэд, даатгуулагч, ААНБ, малчин, оюутан сурагчдыг хамруулан зохион байгуулсан. ААНБ-ын даатгуулагч 670, малчин 443, оюутан сурагч 80 хамрагдсан байна.

Сүмбэр телевизтэй хамтран Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаарх 6 удаагийн танилцуулгыг явуулав.

Нийгмийн сүлжээгээр явуулсан сурталчилгааны тоо 98

Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулдаг 28 ажил олгогч байгууллагын удирдлага хүний нөөц, нягтлан бодогч 62 хүнд нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийг танилцууллаа.

Говьсүмбэр телевизээр Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын талаар Нийгмийн даатгалын дотоод аудит мониторингийн газрын дарга Ганхуяг мэдээлэл, танилцуулга хийж түгээн ажиллаа.



Нийгмийн даатгалын ерөнхий газар, Монголын Тариаланчид Гурил үйлдвэрлэгчдийн Холбоо ТББ, Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс хамтран Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, төсөвт байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан инженер техникийн ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 10-ний өдөр Нийгмийн даатгалын хэлтсийн хурлын танхимд зохион байгууллаа.

Сургалтанд нийт 24 байгууллагын 60 хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнууд оролцож, сургалтыг хөтөлбөрийн хүрээнд заасан мэдлэг ойлголтыг эзэмшсэн. Сургалтанд МЭГазар, НДХэлтэс, Илчлэг-Шивээ ОНӨҮГ,Ус Дулаан ОНӨААТҮГ, БЗӨБЦТС, ЦДҮСүлжээ ТӨХК, , Чойр ТҮГТөмөр зам зэрэг төрийн болон орон нутгийн өмчит компани болон орон нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Шивээ Овоо ХК, Илчит Сансар ХХК, Чойрхайрхан ХХК, Галын Илч ХХК, НИК, Сод Монгол ШТС, Монгол Фү Ёоу Фенг Ресистант компани, Амарбаяжих эрдэс ХХК, Адил Оч ХХК, Петротрак ХХК, Баян Нексус ХХК, Сүмбэр Алт ХХК, Замын 3-р анги, Патрикейн ХХК-ууд болон орон нутгийн төр захиргааны байгууллага, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн, инженер, техникийн ажилтнууд оролцлоо.





Авлигын эсрэг арга хэмжээний талаар

Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан "Авлигын шилэн бөмбөлөг" инфографик, шторкийг байгууллагын албан ёсны цахим хуудаст илээр байршуулав.

Мөн "Зөв зөвд шударга зөв" соён гэгээрүүлэх аяны хүрээнд Авлигатай тэмцэх газраас гаргасан 5 төрлийн зурагт хуудсыг байгууллагын цахим хуудсаар дамжуулан сурталчлан ажилласан. Хэлтсийн авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд гаргасан 2 ширхэг зурагт хуудсыг хэлтсийн мэдээллийн самбарт байршуулан сурталчлан ажиллаж байна.

НДЕГ-аас ирүүлсэн авлигын эсрэг шторкийг Хэвлэл мэдээллийн байгууллагаар нийт 8 удаа цацаж мэдээлэл хүргэсэн.

Хэлтсийн ажилтнуудын хурлаас "Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа" уриа дэвшүүлэн иргэд, даатгуулагчийн гомдол мэдээллийг хүлээн авах 70543216 дугаарын утас ажиллуулж байна. Одоогоор гомдол мэдээлэл гараагүй байна.

Аймгийн ЗДаргын баталсан удирдамжаар Хуулийн хэлтсээс зохион байгуулсан ХАСУМ, хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын дунд 11 сард зохион байгуулсан мэтгэлцээний тэмцээнд Эрх бүхий албан тушаалтан Б. Аюушжав оролцон "Авилгаас урьдчилан сэргийлэхэд хувь хүний ёс зүй чухал" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэн оролцлоо.

Хэлтсийн 2023 онд шинээр Шимтгэл орлогын байцаагчаар Д. Эрдэнэтулга 2023-09-06-наас, Архив-бичиг хэрэг, хүний нөөц хариуцсан ажилтан Б. Жавзан 2023-09-06-наас, Үйл ажиллагааны нягтлан бодогчоор Ч. Буянхишиг 2023-08-15-нд тус тус ажилд томилогдон ажиллаж байгаа 3 ажилтнууд болон хэлтсийн нийт ажилтан албан хаагч нарт Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагаа, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, байгууллагын дотоод журам, Төрийн албаны болон НДБХууль, төрийн албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, хуулиар олгогдсон эрх үүрэг, авлигаас ангид байх сэдэвүүдээр 2023 оны 10, 11 саруудад дотоод сургалтыг зохион байгуулан явууллаа.

АТГ-ын "Шүүр" ажиллагааны зөвлөмжийн хүрээнд хэлтсийн албан хаагчдын томилгоонд дотоод хяналт шалгалтыг явуулж зөрчилтэй томилогоотой Санхүү бүртгэлийн тасгийн даргаахлах нягтлан бодогч П. Гантуяаг 2023-06-05-наас ажлаас чөлөөлж сул ажлын байрыг зарлан орон тоо нөхөгдөх хүртэл ТЗахиргааны албан хаагчаар түр орлон гүйцэтгүүлэх арга хэмжээг авлаа.


Шивээговь сумын нийгмийн даатгалын байцаагчийн сул ажлын байранд Төрийн захиргааны албанд тушаалд томилогдох шаардлагыг хангуулан /тусгай шалгалт өгсөн/ хэлтсийн Тэтгэмжийн байцаагчаар ажиллаж байсан Э. Сарантуяаг 11-р сард томилон ажиллуулж 2 зөрчилийг арилгасан болно.

Сул орон тооны 5 ажлын байрны захиалгыг улирал бүр ил тод байршуулан мэдээ мэдээллийг аймгийн ТАСЗөвлөлд тухай бүр хүргүүлэн 12 дугаар сард сул ажлын байр зарлуулан 3 ажилтан шалгалтанд хамрагдахаар бүртгүүлээд байна.

Хэлтсийн иргэдэд үйлчлэх зааланд "Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа, байцаагч ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой санал хүсэлтээ Нийгмийн

даатгалын хэлтсийн 99082606, Нийгмийн даатгалын ерөнхий газрын /11/ 31-11-31 дугаарын утсанд хандана уу. гэсэн зурагт самбар байруулан санал, мэдээллийг авахаар байрлуулан ажиллав.

Хэлтсийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх самбар, Санхүүгийн мэдээллийн самбаруудад "Авлигагүй нийгмийн төлөө хамтдаа", "Авилгын эсрэг нэгдье", "Олон улсын авлигын эсрэг өдөр 12 сарын 9" зэрэг зурагт хуудас байрлуулан үйлчилгээ авагч иргэдэд авлигын эсрэг ажиллагааг түгээн сурталчлав.



Нийгмийн даатгалын үйлчилгээ авч үйлчлүүлж байгаа 56 иргэнийг хамруулсан Сэтгэл ханамжийн судалгааг 2023 оны 10 дугаар сард зохион байгуулан явуулж дүнг нэгтгэн ажилтнуудын хуралд танилцуулан цаашид нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай, авлига, ашиг сонирхолгүйгээр хүргэх үүрэг даалгаврыг нийт ажилтнуудад өгсөн байна.

2023-05-28-нд АТГазар, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн хамтрсан төрийн албан хаагчдыг чадвахжуулах "Төрийн албан хаагчийн ес зүй, авлига ашиг сонирхолоос урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтанд хэлтсийн ТЗахиргааны 6 албан хаагчийг хамруулав.

НДЕГ-аас зохион байгуулсан "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл", "Төрийн болон нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага, авлига, ашиг сонирхолын тухай хууль"-иар орон нутгийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг ДАМГ-ын дарга н Ганхуягаар ахлуулсан баг амжилттай зохион байгуулж сургалтад хэлтсийн нийт 15 албан хаагчдыг тус тус хамруулан мэдээ мэдээллээр хангаж ажиллаа.


Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар

2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 521 хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэдээллийн баазад бүртгэлтэй байснаас тайлант онд шинээр 37 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоож, 4 иргэн шилжин ирж, хөдөлмөрийн чадвар сэргээгдсэн болон өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн 17 иргэнийг цуцалж өөр аймаг орон нутгаас 5 иргэн шилжин ирж оны эцсийн байлдаар 540 иргэн хөдөлмөрийн чадвараа алдан хувь тогтоолгож нийгмийн даатгал, халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон авч байна. 2023 онд нийт 260 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг сунгаж 26 удаагийн хурлыг зохион байгуулан ажилласан.

Хэлтсийн үйл ажиллагааны талаар

Хэлтсийн үйл ажиллагааны зардал 542594,1 мянган төгрөгөөр батлагдан ажиллах хүчний бүтэц орон тоо, ажлын үүрэг чиглэл, энэ онд хийгдэх ажлууд, зорилго зорилтуудаа тодорхойлон батлаж хэрэгжлтийг ханган мэдээ тайланг дээд газруудад хүргүүлэн ажиллаа.

Байгууллагын ажилтан албан хаагчдын үндсэн болоод нэмэгдэл цалинд 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 272578.9 мянган төгрөг олгож нийгмийн даатгалийн шимтгэлд 33289.6 мянган төгрөг, татварын өглөгийг бүрэн шилжүүлэн ажиллаа.



2023 оны батлагдсан цалингийн сан байцаагч эмчийн сул орон тоо нөхөгдөөгүй, жолоочийг 2022 оны санхүүгийн тайлангийн гүйцэтгэлд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтээр 6 дугаар сарын 01-ний өдрөөс чөлөөлсөнтэй холбогдон 37991.2 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Байгууллагын байр ашиглалттай холбоотой дулаан, гэрэл цахилгаан зэрэг зардалд 47190.9 мянган төгрөг, бичиг хэрэг 1469.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 1887.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 2100.2 мянган төгрөг, цэвэрлэгээний материалын зардалд 2043.6 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 5000.0 мянган төгрөгийг хэмнэлт үүссэн байна.

Хэлтсийн үйл ажиллагааны цэвэрлэгээ, үйлчилгээний зардалд /бага үнэтэй түргэн элэгдэх/ 2075.0 мянган төгрөг, түүнээс урсгал засварын зардалд 8405.4 мянган төгрөг батлагдсаныг 100% зарцуулсан байна.

Тэтгэвэрт гарсан ажилтанд 12038.3 мянган төгрөгийн, ажилтнуудын нийгмийн асуудал, тэтгэмж, дэмжлэгт 4794.0 мянган төгрөг батлагдсанаас ахмад настнуудын тэтгэмж, тусламжид 1200.0 мянган төгрөг, ажилтнуудын тусламж дэмжлэгт 663.0 мянган төгрөгийг зарцуулж энэ онд ажилтнуудын ар гэрт гачигдал зовлон гараагүй учир 2430.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Нийт батлагдсан төсвөөс 45421.2 мянган төгрөгийг хэмнэн үр ашигтай зарцуулан ажиллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу 2023 оны 06 дугаар сарын 26 өдөр хэлтсийн даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж хагас жилийн үндсэн хөрөнгийн тооллого хийсэн. Тооллогоор байгууллагын барилга байгууламж 687351.2 мянган төгрөг, 44 төрлийн тоног төхөөрөмж 40385.4 мянган төгрөг, 65 төрлийн тавилга эд хогшил 11666.0 мянган төгрөгний нийт 739402.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдон үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мэргэжлийн хяналтын газраас шилжиж ирсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолын дагуу 2023 оны 07 сарын 01-ний өдрөөр бүртгэж авсан.

Үндсэн хөрөнгөөс хасагдах болон үнэ шинэчлэн тогтоох тухай, Өмч хамгаалах байнгын зөвлөлийг 2023 оны 10 сарын 10 ний өдөр хуралдаж ашиглагдах боломжгүй болсон 1 097 101,10 төгрөг, үнэ шинэчлэн тогтоох 298 960 төгрөгийн саналыг хүргүүлсэн.

2023 оны жилийн эцсийн тооллогыг 12 дугаар сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 18-ны өдрийн хооронд явуулахаар ажлын хэсгийг томилоод байна.

2023 оны тайлангийн жилд төсвийн зардлыг ангилал бүрээр хэтрүүлэн зарцуулсан зарцуулалт гаргаагүй санхүүгийн сахилга, хариуцлагыг мөрдөн хэрэгжүүллээ.

Дүгнэлт, санал

2023 онд дэвшүүлсэн зорилтуудыг амжилттай гүйцэтгэж ажилласан хэдийч цаашид анхаарах асуудалууд хийж гүйцэтгэх ажлууд байна.

- 1. Нийгмийн даатгалын сангуудын авлагыг бууруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан авлагын хэмжээг 2024 онд 50 хувь багасгах Шивээ-овоо ХК-ий авлагыг ХНХЯам, НДЕГ, аймгийн Засаг даргын хүрээнд авлагыг барагдуулах арга зам хайх, хамтарч ажиллах санал дэвшүүлэх
- 2. 2024 онд Нийгмийн даатгалын шинэчилсэн багц хууль хэрэгжихтэй холбогдуулан байцаагч ажилтнуудын ажлыг ачааллыг жигдрүүлэх үүднээс бүтэц орон тоо нэмэгдүүлэх саналыг шийвэрлүүлэх
- 3. 2024 онд Говьсүмбэр аймаг байгууллагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх аймгийн Засаг даргын захирамж гарсантай холбогдуулан хэлтсийн байрны тохижилт, гадна гудамж талбайн өнгө үзэмжийг нэмэгдүүлэх засах шаардлагатай ажил хийгдэх тул хэлтсийн 2024 оны үйл ажиллагааны үндсэнхөрөнгө худалдан авах, урсгал засварын зардалыг нэмэгдүүлэн батлуулах саналыг НДЕГазарт тавьж шийдвэрлүүлэх гм
- 4. Орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд хэмнэгдсэн зардлаас Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд заасан хувь хэмжээгээр сан үүсгэн зарцуулах эрхийг бий болгох /Манай байгууллагад ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон байгууллагын харъяа 10 ахмад настан, харъяалалгүй Засаг даргын захирамжаар хувиарлагдан ирсэн 2 нийт 12 ахмад настан харъяалагдаж байна. 2023 онд үйл ажиллагааны зардлын ахмадын санд 350.000 төгрөг батлагдсан нь ахмад настны нийгмийн хамгааллын нэг асуудлыг шийдвэрлэхэд хүрэлцэхгүй байна./